



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 10 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 02/01 дүгээр хурлын шийдвэр, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн ерөнхий газар, Иргэний нисэхийн үндэсний төв, түүний харьяа салбар нэгжийн ажилтнуудыг “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх үнэмлэхийн хураамжийг тэглэхтэй холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалын “А.Хувь хүн” хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулан хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тушаалыг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс холбогдох журмын дагуу мөрдөж ажиллахыг Аюулгүй байдал, хамгаалалтын алба (Б.Сэр-Од)-нд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нисэх буудлуудын үйлчилгээний газар (С.Нацагдорж), Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Д.Пүрэв-Очир)-т тус тус даалгасугай.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.БАТСАЙХАН

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн
А/63... дугаар тушаалын хавсралт



НИСЭХ БУУДЛЫН ХОРИОТОЙ БОЛОН ХАМГААЛАГДСАН
БҮСЭД НЭВТРЭХ ҮНЭМЛЭХИЙН ХУРААМЖ

№	Нэвтрэх үнэмлэх хүсэгч	Хугацаа	Хураамж (төгрөг)
А.Хувь хүн			
1	Иргэний нисэхийн ерөнхий газар, Иргэний нисэхийн үндэсний төв, түүний харьяа салбар, нэгжийн ажилтнууд	2 жил	төлбөргүй

Нэмэлт:

Нэвтрэх үнэмлэхийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд дахин олгохдоо Иргэний нисэхийн ерөнхий газар, Иргэний нисэхийн үндэсний төв, түүний харьяа салбар, нэгжийн ажилтнууд 5,500 төгрөг (НӨАТ тооцсон дүн) төлнө.

--- оОо ---